



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.27 № 09/27 ВАТ-САГ/2013/56-СТА-ТОУТ

ЗӨРЧИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ий 2012 оны санхүүгийн тайланд аудит хийхэд Төрийн өмчийн хорооны хяналт шаардлагатай дараах зөрчил илэрлээ.

ТӨХ-ны 2012 оны 10 дугаар сарын 18-ны 449 дүгээр тогтоол гарсны дагуу 2012 оны 10 дугаар сарын 26-д тус компаний Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ж.Төмөрбаатартай гүйцэтгэх захирал П.Маргад-Эрдэнэ хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан боловч уг гэрээний 6.21-д " сард 1955,0 ам долларийн цалин хөлс олгоно" гэж заасан нь "Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай" хуулийн 4.1-д "Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх..." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Мөн тус компаний 4,392,086,716.80 төгрөгийн үндсэн хөрөнгийг ТӨХ-ний тогтоолоор "Монголын цахилгаан холбоо" ХК-д шилүүлсэн гэх боловч "Монголын цахилгаан холбоо" ХК 4,370,849,753.20 төгрөгөөр буюу 21,236,963.60 төгрөгөөр дутуу бүртгэсэнг аудитын явцад тулган баталгаажууллаа. Энэ хөрөнгийн шилжилт хөдөлгөөний талаар ТӨХ-ноос "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-д албан ёсны тогтоол ирээгүй, ТӨХ энэ байгууллагаас санал аваагүй байгаа нь ТӨХ-ны 2012 оны 44 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 4.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал/ нь илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх тухай болон бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авах саналтай байгууллагын удирдлага, өмч эзэмшигч байгууллагаас албан ёсоор зөвшөөрөл авч, холбогдох материалыг энэ журмын 1,9-д заасны дагуу бүрдүүлэн ирүүлж, Төрийн өмчийн хорооны шийдвэрт зааснаар хэрэгжүүлж, баланс тайланд хөдлөл өөрчлөлт хийнэ" гэж заалтыг зөрчсөн байна.

2008 онд Мэдээлэл шуудан, харилцаа холбоо, технологийн газар /хуучин нэрээр/ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Сумын түвшний сүлжээний төсөл" арга хэмжээний дагуу 33 суманд шилэн кабель, сүлжээний тоног төхөөрмж суурьлуулсан бөгөөд энэхүү ажлын 10-20% буюу 600,8 сая төгрөгийн санхүүжилтийг "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК хийж, 2009 онд улсын комисс хүлээн авсан боловч ТӨХ-ны шийдвэр одоо болтол гаргаагүйгээс "дуусаагүй барилга" дансанд бүртгэгдсэн хэвээр байна.

ТӨХ-ны 2009 оны 344 дүгээр тогтоолоор актлагдсан 203, 204, 205, 206, 207, 208, 209, 210 дугаар релейний станцын антен цамхагийг акталж, "Тэнгэр Уул" ХХК,

“Бирокон” ХХК-д дуудлага худалдаагаар худалдсан байна. Гэтэл уг антен цамхагийг “МХС” ХХК буцаан нь түрээслэн авч түрээсийн төлбөр төлж байна. Тухайлбал, 2012 онд 13,5 сая төгрөгийн түрээсийн төлбөр төлсөн байна.

Дээрх асуудлууд нь ТӨХ “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлд заасан: 1/ төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах; 2/ төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах; 3/ төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм, нормативыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох; 6/ төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавих,” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих” гэж заасныг үндэслэн дээр дурьдсан асуудлыг шийдвэрлэн зөрчлийг арилгаж, гүйцэтгэлийг гарган 2013 оны 7 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг тус төвийн ТӨХ-ны Төрийн бичгийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Д.Одмаа, “МХС” ХХК-ий захирал П.Маргад Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР**

**ПАНТЕР МИДЛАНД АУДИТ ХХК
ЗАХИРАЛ**

ЗӨВШӨӨРСӨН:

“МХС” ХХК-ИЙ ЗАХИРАЛ



Л.ОДГЭРЭЛ

Б.БЯМБАСҮРЭН

П.МАРГАД ЭРДЭНЭ